

Хэнтий аймгийн ЗДТГ-ын 2014 оны Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

2014.11.12

д/д	зорилтууд	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	хэрэгжилт
1	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>Авилгын эсрэг үйл ажиллагааг 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн дотор төлөвлөх</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан, сумдын Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх</p> <p>Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвлөн зарцуулах</p> <p>Авилгын эсрэг үйл ажиллагааны тайланг АТГ-т хүргүүлэх</p>	<p>аймгийн ЗДТГ-ын 2013 онд хэрэгжүүлсэн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд үнэлгээ хийх, 2014 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлыг АОЭХ, “Шинэ сонор” сонины ажилтнууд, Скаутын зөвлөл зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж аймгийн ЗДТГ-ын даргын 2014 оны 2 сарын 14-ний өдрийн а/25 тоот тушаалаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.</p> <p>Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 3.0 сая төгрөг төсөвлөн зарцуулсан.</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг АТГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан болно.</p>
2	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөө</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/</p>	<p>2014 оны 1 дүгээр сарын 17-нд АЗДТГ-ын 24 албан хаагчдад ХАСХОМ-ын талаар сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Авлигатай тэмцэх газраас Хэнтий аймгийн ЭБАТ-д 2014 оны 6 дугаар сарын 6-нд ХАСХОМ бүртгэх, хадгалах, хамгаалахтай холбоотой асуудлаар сургалт зохион байгууллаа. 2014 оны 9 дүгээр сарын 20-нд Баянмөнх сумын Төрийн байгууллагын 68 албан хаагчдад Ёс зүйн талаар сургалт, 2014 оны 9 дүгээр сарын 22-нд</p>

<p>тэй авах нөхцөлийг хангах</p>	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллагад түгээн хүргэх</p>	<p>Батноров сумын Цэцэрлэгийн ажилчдад Ёс зүйн сургалт, 2014 оны 10 дугаар сарын 3-нд АЗДТГ-ын 35 албан хаагчдад ёс зүйн дүрмийн талаархи, 10 сарын 17-нд нууцын тухай хуулиудаар сургалтыг тус тус зохион байгууллаа.</p> <p>Ажил Олгогч Эздийн Холбоо ТББ, СКАУТ-ын салбар, Шинэ Сонор сонины хамт олон хамтраад “Авлигын эсрэг-Түншлэл ба ТББ, Иргэдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж</p> <p>Орон нутагт сайн засаглалыг бэхжүүлэх, авлигатай тэмцэх уур амьсгалыг нийт иргэдийн хүрээнд бий болгож, авлигын эсрэг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтоон, үр дүнтэй хэрэгжүүлэх, авлигын эсрэг хамтран түншүүд болох ТББ, иргэдтэй хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.</p> <p>“Хууль дүрэм бодит амьдрал-2” аяны хүрээнд хөдөөгийн малчин иргэдийн Хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг 03 сарын 10-ний өдөр Цэнхэрмандал сумын Согоот баг дээр зохион байгуулж, Согоот багийн иргэд, малчид нийт 57 хүн хамрагдав.</p> <p>Байгууллага шудрага ил тод байдлын самбартай эсэх, самбарт төсөв санхүү, ХАА-ны мэдээлэл болон бусад мэдээлэл байршигдсан эсэх, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа болон тухайн байгууллагатай холбоотой мэдээ мэдээллийг иргэд авахад хялбар эсэх, судалгаа авахад удирдах ажилтан болон албан хаагчдын хандлага ямар байсан зэрэг ажиглалтын судалгааг хийж судлаачид байгууллага бүр дээр тайлан бичиж сайжруулахад анхаарах зөвлөмж гаргаж ажилласан. Энэхүү судалгааг 7-н асуумжын дагуу нийт 45 байгууллагын 350 ажилтан албан хаагчид судалгаанд оролцуулах төлөвлөгөөтэй байснаас 45 байгууллагын 377 албан хаагч оролцсон юм. Судалгааны дүнг олон нийтэд танилцуулах өнгөрсөн онтой харицуулан ахиц дэвшил гарч байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Тунгалаг төсөвт</p>
----------------------------------	--	--

		<p>байгууллага нээлттэй хэлэлцүүлгийг 3 сарын 27 нд Аймгийн иргэний танхимд зохион байгууллаа. АЗДТГ-ын Санхүү Төрийн Сангийн Хэлтэс, Аймгийн Худалдан Авах Ажиллагааны Алба, Мерси Кор ОУБ, ИНБ-ын сүлжээ, Хэвлэл мэдээллийн байгууллага Хэрлэн сумын төрийн болон төрийн өмчит 45 байгууллагын дарга эрхлэгч нягтлан бодогч, ИНБ-ын гишүүд, иргэд гэсэн нийт 85 хүн оролцов. Судалгааны дүн өнгөрсөн онтой харицуулахад 2013 онд төсөв санхүүгээ ил тод мэдээлдэг 5 байгууллага байсан бол 2014 онд нийт 45 байгууллагын 82 % нь ямар нэгэн хэлбэрээр мэдээлж хэвшээд байна.</p> <p>“Боловсролын салбарын төсвийн ил тод байдлыг хангах тухай санхүүчдийн сургалт, зөвлөгөөн”-ийг 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Боловсролын газрын сургалтын танхимд амжилттай зохион байгууллаа.</p> <p>Орон нутгийн төр, ИНБ, иргэдэд чиглэгдсэн сургалт сурталчилгааны ажлуудыг явуулсанаар засаглалын хууль тогтоомжийг мэддэг, хэрэгжүүлдэг зан үйлд сургаж идэвхжүүлж ирсэн. 523 хүнд сургалт мэдээлэл өгсөн бөгөөд сургалтанд хамрагдсан иргэд хуулийн хэрэгжилтийг хангах мэдлэг мэдээллийг улам цааш нь мэдээлж амьдралд хэрэгжүүлэх ажлыг санаачлага гарган ажилласнаараа сургалтын гол үр дүн гарсан.</p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагааг идэвхжүүлэхэд төслийн үйл ажиллагааны талаар төрийн байгууллагууд иргэд олон нийтэд авлигын асуудлаар мэдээлэл өгөх, иргэдийн дуу хоолой санал санаачлагыг сонсох, соён гэгээрүүлэх, нөлөөллийн олон үйл ажиллагааг зохион байгуулж, авлигын эсрэг орон нутгийн төрийн байгууллагын хүчин чармайлтыг иргэдэд ойлгуулж төр, ИНБ хамтран ажиллах, төрийн байгууллагууд мэдээллээ ил тод болгох,</p>
--	--	---

			<p>Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах тал дээр санаачилгатай ажиллаж байна.</p> <p>Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сайн засаглал, авлига, хүнд суртал, мэдээллийн ил тод байдлын асуудлаар мэдээлж иргэдийн дуу хоолойг төрийн байгууллагуудад хүргэх, төрийн мэдээллийг иргэдэд хүргэхэд санаачлага гарган олон ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг сум болон байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлсэн.</p>
3	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох</p>	<p>Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулах</p> <p>Дээрх бодлогын баримт бичиг болон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, харилцан санал солилцох боломжийг бүрдүүлэх</p>	<p>Аймгийн Засаг дарга Автозамын тухай хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд “орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах журам”-ын төслийг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООСОН ШИЙДВЭР ГАРГАХ ЖУРАМд нийцүүлэн 2014 оны 3 дугаар сард 18 сум, 4 тосгоноос нөлөөлийн шинжилгээ хийж, ХЗЯ-д хүргүүлэн улсын нэгдсэн санд бүртгүүлж аймгийн хэмжээнд дагаж мөрдөн ажиллаж байна.</p>
4	Төрийн хяналтын үйл ажил-лагааны	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөсөн байх	Тухайн жилд хяналт шалгалт хийх 332 объектыг зарлаж, 22 чиглэлийн хяналтын хуудсаар хуулийн этгээд 583, иргэн 697

<p>ил тод, нээлттэй байдлыг хангах</p>	<p>Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг болон хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний талаар олон нийтэд цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх</p>	<p>хамрагдаж үүний 33.9% нь төлөвлөгөөт, 61.87% нь төлөвлөгөөт бус, 4.5% нь гүйцэтгэлийн шалгалтын төрлөөр хийгдсэн.</p> <p>Хяналтанд 234 хуулийн этгээд, 196 иргэн хамрагдсанаас 59.76% нь урьдчилан сэргийлэх, 29.53% нь тандалт судалгаа, 10.69% нь хяналт шинжилгээний хэлбэрээр хийгдэж, 168 албан шаардлага, 114 акт, 154 дүгнэлт гаргаж олон нийтэд мэдээлж ажиллаа.</p> <p>Аймгийн МХГ-ын 2014 оны жилийн төлөвлөгөөний дагуу Баянмөнх, Дархан, Цэнхэрмандал, Баян-Адрага зэрэг хөдөөгийн 9 сумын төсвийн 53, Хэрлэн сум, аймгийн төсвийн 5, аж ахуйн 1 байгууллага, Тариалан эрхлэх сан бүгд 60 байгууллага, нэгж, санг шалгах аас 51 байгууллагад шалгалт хийж, 6 актаар 1263,4 мян.төг-ийн нөхөн төлбөр ногдуулаад 5 актын 898,4 мян.төг-ийн төлбөр барагдаж, 1 актын 365,0 мян.төг-ийн хугацаа болоогүй, илэрсэн зөрчилд нь 69 заалт бүхий 11 албан шаардлага бичиж, 10 нь хугацаандаа биелж, 1 нь хугацаа болоогүй, Баянмөнх сумын ЭМТ, Дархан сумын ЗДТГ-ын 2 албан тушаалтныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтаар тус бүрийг 960,0 мян.төг-өөр торгож шийтгэсэн байна.</p> <p>Монгол улсын Төсвийн тухай хуулинд заасан Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангуудыг шалгалтанд хамруулахаар Төсвийн менежер үр дүнгийн гэрээнд тусгай захиалгат бүтээгдэхүүнээр тусгасны дагуу Байгаль хамгаалах, Сум хөгжүүлэх, Малыг эрсдлээс хамгаалах, Ахмадын болон ЖДБД сангуудын хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтанд шалгалт хийж байна</p> <p>Шалгагдсан байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хяналтын хуудсаар дүгнэхэд 72,5 % нь бага, 27,5 % нь дунд эрсдэлтэй үнэлэгдлээ.</p>
--	--	---

			Мэргэжлийн дүйцэвэрлэлтэй холбоотойгоор мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа, хяналт шалгалтын мэдээллийг facebook, вэб хуудасад 13 өдөр тавьж, Хэнтий мэдээ сонинд 9 удаа мэдээлэл, ярилцлага нийтлэж, Өндөрхаан телевизээр 19 мэдээ, ярилцлага нэвтрүүлж, 258 гарын авлага, 189 зөвлөмж сэрэмжлүүлгийг ард иргэдэд тарааж ажиллаа.70563113” нээлттэй утсанд нийт 12 гомдол мэдээлэл ирснийг шуурхай шийдвэрлэж, Хэнтийн мэдээ сонины “Асууval хариулъя” буланд нийтэлж мэдээллээ.
5	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тус-ламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт 2014 оны 04 дүгээр сарын 01-ний дотор байршуулсан байх	Орон нутгийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг khentii.mn сайт дахь шилэн данс хуудасны төсвийн гүйцэтгэл цонхонд байршуулсан.
		2014 оны төсвийг 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь 2014 оны 04 дүгээр сарын 01-ний дотор цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	2014 оны орон нутгийн төсвийг аймгийн ИТХ-ын 2013 оны 12 сарын 04-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсаныг бүрэн эхээр khentii.mn сайт дахь шилэн данс хуудасны хэнтий аймгийн төсөв цонхонд байршуулсан. Орон нутаг, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбаруудын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь khentii.mn сайт дахь шилэн данс хуудасны төсвийн гүйцэтгэл цонхонд байршуулсан. Тухайн салбарын мэргэжилтнүүд салбарынхаа мэдээллийг өөрийн байгууллагын мэдээллийн самбарт болон цахим хуудсанд байршуулдаг
		Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/-ийг цахим хуудас болон	2014 оны төсөвт тодотгол хийж аймгийн орлого зарлагыг 59,3 тэрбум төгрөгөөр батлагдсаныг khentii.mn сайт дахь шилэн данс хуудасны хэнтий аймгийн төсөв цонхонд болон мэдээллийн

		<p>мэдээллийн самбарт байршуулсан байх</p>	<p>самбарт тодотгол хийгдсэнээс хойш 14 хоног дотроо багтааж байршуулсан.</p>
		<p>Төсвийн орлого бүрдүүлэлтийн /татварын орлого, татварын бус орлогын талаарх/ мэдээлэлийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх</p>	<p>Орон нутгийн орлогын 2014 оны төлөвлөгөө, биелэлтийг сумдаар нь гаргаж нэгтгэсэн файлыг khentii.mn сайт дахь шилэн данс хуудасны аймгийн орлогын мэдээлэл цонхонд болон мэдээллийн самбарт байршуулсан.</p>
		<p>Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт /батлагдсан болон байгуулагдсанаас нь хойш ажлын 14 өдрийн дотор/, концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/-ийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж, цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулсан байх</p>	<p>Хэнтий аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 6 сарын 4-ний өдрийн 32 тоот тогтоолоор орон нутгийн концессийн 3 зүйлийн жагсаалтыг баталсан бөгөөд энэ талаархи мэдээллийг орон нутгийн Өндөрхаан, Хэнтий телевизэд шторок бэлтгэн иргэдэд хүргэж байна. Мөн аймгийн цахим хуудсанд байршуулсан.</p>
		<p>Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн</p>	<p>2014 онд Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авч байгаа иргэдийн нэрсийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулан сар бүр шинэчилж байна.</p>

		<p>нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчилсэн байх</p> <p>Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх</p>	<p>ЭМЯамны дэргэдэх Глобаль сангийн ДОХ, сүрьеэгийн төслийн санхүүжилтээр “100% бэлгэвч хэрэглэх” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн сургалтууд, Японы ядуурлын бууруулах сан, Азийн хөгжлийн банкны хөдөөгийн болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох төслийн санхүүжилтээр Цэнхэрмандал суманд гэр цэцэрлэгийн 15,033,500 төгрөгийн өртөг бүхий 2 гэр бүрэн тавилга, тоног төхөөрөмжтэй нь олгосон тухай, Японы элчин сайдын яамны “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Бор-Өндөр цогцолбор сургуулийн хичээлийн байрны их засварын ажлын талаархи мэдээллийг тухай бүр www.khentii.mn цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн.</p>
6	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p>	<p>Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх</p> <p>Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим</p>	<p>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн, хугацааг сунгуулахаар материалаа өгсөн аж ахуй нэгжүүдийн материалыг комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэж аймгийн засаг даргын захирамжыг khentii.mn сайт, тусгай зөвшөөрлийн тайлан мэдээ нэртэйгээр байршуулсан. /http://khentii.mn/index.html/</p> <p>Эрүүл мэндийн болон боловсролын байгууллагуудад мэргэжлийн үйл ажиллагааг явуулах тусгай зөвшөөрлийн жагсаалт, түүнийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудас болон ЭМГ болон БГ-ын мэдээллийн самбарт байршуулан ажиллалаа.</p> <p>2014 онд Тусгай зөвшөөрлийн комиссын хурлын шийдвэрийг үндэслэн а/03, а/114, а/315, а/552 дугаар захирамжаар 7</p>

		хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулсан байх	байгууллагад тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 38 байгууллагын зөвшөөрлийг сунгаж, хүсэлтээ ирүүлсэн 6 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалсан тухай захирамжийг цахимд байршуулан иргэдэд мэдээллийг ил тод хүргэж ажилласан болно. Тусгай зөвшөөрөл бүхий ЭМБ-уудын судалгааг цахим хуудсанд байршуулсан,
		Хуулиар хориглоогүй бүртгэлийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал /хууль тогтоомжид зааснаар бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүд/-ыг ханган цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	
7	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулсан байх /тухай бүр шинэчилсэн/	2014 оны 11 дүгээр сарын байдлаар Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын зарыг 2 удаа, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын зарыг 1 удаа khentii.mn цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулсан.
		Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх	Төрийн жинхэнэ албан мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох Өндөрхаан ТВ, Хэнтий ТВ-ээр зарлуулсан.
		Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулсан байх /тухай бүр шинэчилсэн/	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам, үйлчилгээний стандарт, албан хэрэг хөтлөлтийн заавар, иргэд нэвтрэх журмыг ус тус шинэчлэн боловсруулан батлуулж, тухай бүр нь аймгийн цахим хуудсанд байршуулсан.
		Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нээлттэй байдлыг ханган цахим	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нээлттэй байдлыг ханган томилгоо хийгдсэн захирамж, тушаалуудыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.

		хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	
		Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр “Цахим Хэнтий хөтөлбөр”-ийн хүрээнд бүх төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтан болон мэргэжилтэн, бичиг хэргийн ажилтнуудын өдөр тутмын ажилд ашиглагдах нэг стандарт бүхий цахим мэдээллийн цогц систем OffShare програмыг шинээр хийлгэн ЗДТГ-т ажиллуулж эхлээд байна.
8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарласан байх /Төсөв батлагдсанаас 1 сарын дотор /	2014 оны аймгийн төсөв батлагдсаны дараа 1 сарын дотор Өглөөний сонины 2014 оны 01 сарын 03 өдрийн дугаарт нийтлэгдсэн.
		Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулсан байх	Зохион байгуулагдсан 72 тендерийн урилгыг ЗГ-н ХАА-ны Хяналт Үнэлгээ шинжилгээний цахим хуудаст /www.e-procurement.mn/ болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж ажиллаж байна.
		Тендерийн урилгыг цахим хуудас болон үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх	Зохион байгуулагдсан 72 тендерийн урилгыг ЗГ-н ХАА-ны Хяналт Үнэлгээ шинжилгээний цахим хуудас /www.e-procurement.mn/ орон нутгийн цахим хуудас /www.khentii.mn/ , 35 нээлттэй тендерийн урилгыг Үндэсний өдөр тутмын Өглөөний сонинд байршуулж ажилласан.
		Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх мэдээллийг	72 тендерийн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний дүн, хугацаа зэргийг ЗГ-н ХАА-ны Хяналт Үнэлгээ шинжилгээний цахим хуудаст /www.e-procurement.mn/, Аймгийн цахим хуудас /www.khentii.mn/ цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж ажиллаж байна.

	цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	
	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг нээлттэй байлгах	Шалгарсан болон шалгараагүй оролцогчийн мэдээллийг ЗГ-н ХАА-ны Хяналт Үнэлгээ шинжилгээний цахим хуудас /www.e-procurement.mn/ болон аймгийн цахим хуудас, албаны мэдээллийн самбарт байршуулж ажиллаж байна.
	Тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар танилцуулсан байх	72 тендерт Оролцогчдын шалгарсан болон шалгараагүй шалтгааныг албан бичгээр хуулийн үндэслэлийг тайлбарлан хүргүүлж ажиллаж байна.
	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлангийн нээлттэй байдалыг хангах	Захиалагчийн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг улирал бүр аймгийн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.
	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх	Зөрчил байхгүй.
	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг нээлттэй болгох	Худалдан авах ажиллагаанд хийгдсэн аудитын тайлангийн дүгнэлт нь захиалагчийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитын тайланд хамт гардаг тул холбогдох хэлтэс хариуцан мэдээллийг нээлттэй болгосон.
	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн	Аймгийн ЗД-н захирамжаар байгуулагдсан 27 үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд "Хан Хэнтий цахим хөгжлийн төв" ТББ, Мерси Кор ТББ, Зүүн бүсийн хөгжлийн гарц ТББ, хувийн хэвшил, иргэний давхардсан 36 төлөөлөл оролцож ажилласан.

		хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх	
9	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг нээлттэй болгох	Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт”-ын загвар, “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт боловсруулах заавар”-ын дагуу албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг 2012 онд шинэчлэн боловсруулан батлуулсан. Цахим мэдээллийн цогц систем OffShare програмд албан хаагчдын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг суулгаж өгснөөр нээлттэй ил тод болж байна.
10	Төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;	Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж тодорхой үйл ажиллагаа явуулах, үр дүнд хүрэх Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх Хамтын ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл хүргэх	Орон нутагт сайн засаглалыг бэхжүүлэх, авлигатай тэмцэх уур амьсгалыг нийт иргэдийн хүрээнд бий болгож, авлигын эсрэг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтоон, үр дүнтэй хэрэгжүүлэх, авлигын эсрэг хамтран түншүүд болох ТББ, иргэдтэй хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Ажил Олгогч Эздийн Холбоо, Скаутын зөвлөл, “Шинэ сонор” сонины редакцитай хамтран “Авлигын эсрэг Түншлэл ба ТББ, Иргэдийн оролцоо” төслийг хэрэгжүүлсэн. Уг төслийн багтай хамтран Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар иргэдийн дунд авилгын талаархи ойлголт мэдлэг тогтоох, иргэд, төрийн албан хаагчдын авлигын талаархи ойлголт ямар хэмжээнд байгааг тандах, 2014 онд хэрэгжүүлэх АЭҮАТ-нд иргэд, олон нийтийн саналыг тусгах зорилготойгоор санал асуулгын хуудсыг боловсруулан орон нутгийн төрийн албан хаагчид, иргэдээс санал авч дүнг нэгтгэн 2014 оны АЭҮАТ-нд тусган ажиллаа. Мөн хамтын ажиллагааны талаархи мэдээллийг орон нутгийн “Шинэ сонор” сонины 59 дугаарт нийтэлж, иргэд олон нийтэд хүргэсэн.

авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих	<p>Мөн 2014 оны 4-р сарын 15-нд “Хэнтий” ТВ-ээр “Авлигын эсрэг – Түншлэл ба ТББ, Иргэдийн оролцоо” төслийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын АЭҮАТ-ний талаар олон нийтэд сурталчилан таниулах, хэрэгжилтэнд хэрхэн анхаарч ажиллах талаар ТВ шууд нэвтрүүлэгт төслийн баг, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ орж олон нийтэд мэдээлэл хүргэсэн.</p> <p><i>/төслийн тайланг хавсаргав/</i></p> <p>Төрийн байгууллагын мэдээллийг иргэдэд ил тод нээлттэй болгоход дэмжлэг үзүүлснээр иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх, төр мэдээллээ олон нийтэд тасралтгүй хүргэх тогтолцоог орон нутагт бий болгох, төр мэдээллээ хүргэх бүхий л сувгийг эрэлхийлэх, орон нутагт ажиллаж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагыг чадавхжуулах, үйл ажиллагааг нь дэмжиж, төрийн мэдээлэл иргэдэд шуурхай хүрэх нөхцөл бололцоо бүрдэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хэвлэлийн Хүрээлэнгийн Зүүн бүсийн салбартай хамтран</p> <p>“Төрийн мэдээлэл- түмний оролцоо” төслийг хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p><i>/төслийн тайланг хавсаргав/</i></p> <p>Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэд олон нийтийн дуу хоолой санал санаачлагыг орон нутгийн засаг захиргааны шийдвэрт тусгах, төр иргэний нийгмийн хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр ИНБ-уудаас гарсан санал санаачлагыг дэмжих зорилгоор Аймгийн Засар даргын ивээл дор 540 дугаар захирамжаар 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгууландан ТББ-уудын III-аар чуулганыг 2014 оны 10 дугаар сар 23,24-ны өдрүүдэд Чингис хотноо амжилттай зохион байгууллаа. Чуулганыг Хэнтий аймгийн ИНБ-уудын сүлжээнээс санаачилсан</p>
---	--

			бөгөөд АЗДТГ, Мерси Кор ОУБ-лага хамтран зохион байгуулж 15 сумын 72 ТББ-уудын төлөөлөл нийт 100 хүн орчим оролцлоо. Чуулганаар ТББ-уудыг чадваржуулах сургалт, ТББ-уудын гишүүдийг хооронд нь танилцуулах спортын арга хэмжээ, ТББ-уудад тулгамдаж байгаа асуудал болон түүнийг шийдвэрлэх арга замыг хэлэлцэн “Уриалга” гарган чууллаа. Энэхүү арга хэмжээнд аймгийн төсвөөс 1,5 сая төгрөгийг зарцуулсан.
11	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг мөрдүүлэх	<p>Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулах</p> <p>Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлэх</p>	<p>Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан ёс зүйн дүрэм болон аймгийн ЗДТГ-ын Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг ажилтнуудад танилцуулан ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах талаархи батлагааг гаргуулан авлаа.Мөн аймгийн БСГ-тай хамтран ЕБС-иудын захиралуудтай байгуулах хөдөлмөрийн гэрээнд авилга, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой заалтуудыг оруулж, гэрээний үүргээ биелүүлж ажиллахыг ЕБС-ийн захирлуудад даалгалаа.</p> <p>Мэдээлэл технологийн хурдтай хөгжиж байгаа өнөө үед иргэдэд ухаалаг хэлбэрээр төрийн мэдээ мэдээллийг хүргэх, санал хүсэлт өргөдөл гомдлыг хүлээн авах ухаалаг гар утаснуудад зориулагдсан Smart khentii програмыг 2 хувилбараар шинээр хийлгэж цахим орчинд байршуулаад байна.</p> <p>Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай дамжуулан мэдээлэх, зарлах, санал хүсэлт хүлээн авах зориулалттай тусгай дугаартай холбогдож ажиллах системийг шинээр хийлгэж ашиглахад бэлэн болоод байна.</p>

		<p>Зөрчлийн талаарх бүртгэл хөтлөх, зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г хэрэгжүүлэх, зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх асуудлыг хариуцах, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаар хамт олонд тухай бүр мэдээлж, тайлан, мэдээг АТГ-т хүргүүлэх ажлыг хариуцсан ажилтанг томилж ажиллуулах</p>	<p>Мөн “Иргэдээ сонсьё 70563111” төвийн 70563111 тусгай дугаарын утас, 70563111 факс, 70563111@khentii.mn, хаягаар зөрчлийн талаархи мэдээллийг хүлээн авах бүрэн боломжтой.</p>
12	<p>Давхар ажил эрхлэх боломж-той эсэхийг шийдвэрлэх</p>	<p>Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмыг ажилтнуудад танилцуулж, хэрэгжүүлж албан хаагчдад танилцуулах, албан тушаалтанд давхар ажил эрхлэх тохиолдолд хуульд заасны дагуу зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулах, давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмыг ажилтнуудад танилцуулж, хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулагдсан давхар ажил эрхлэхтэй холбоотой хязгаарлалтыг нийт ажилтнуудад танилцуулж ажиллаж байна.</p> <p>Мөн АТГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчдын судалгааг гарган нэгтгэж АТГ-т хүргүүлсэн.</p>

13	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	Засаг даргын захирамж, ЗДТГ-ын тушаалын /төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад/ ил тод, нээлттэй байдлыг хангах ажлыг зохион байгуулах Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг нээлттэй болгох	2014 онд аймгийн Засаг даргын захирамж - 584 , аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал - 116 гарсныг аймгийн цахим хуудас болох khentii.mn байршуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам, үйлчилгээний стандарт, албан хэрэг хөтлөлтийн заавар, иргэд нэвтрэх журмыг ус тус шинэчлэн боловсруулан батлуулж, тухай бүр нь аймгийн цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.
14	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээл-лийг хүлээн авч шалгах	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилах Иргэдээс өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах (утас, хайр-цаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр) Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах “Иргэдээ сонсьё 3111”-төвд төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын талаарх мэдээллийг “Хэнтий ТВ”, “Өндөрхаан ТВ”-ээр сард 3 удаа, АЗДТГ-ын сар бүрийн “Мэдээлэл “сэтгүүлд сар бүр, “Khentii.mn” сайтад 7 хоног тутам, “Иргэдээ сонсьё 3111” төвийн мэдээллийн самбарт тухай бүрт шинэчлэн гаргасан байна. Иргэдийн өргөдөл, гомдлоо гаргах, шуурхай шийдвэрлүүлэх эрхээ эдлэх нөхцөлийг бий болгож төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, иргэдэд ойртуулах үүднээс “Иргэдээ сонсьё” 70563111” төвийн тусгай дугаарын утсаар “Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах шийдвэрлэх журам”-ыг аймгийн Засаг даргын 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/64 тоот захирамжаар баталж 2013 оны 03-р сарын 01-нээс “Иргэдээ сонсьё 70563111” төв байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Мөн 2014 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Мэдээлэл технологийн хурдтай хөгжиж байгаа өнөө үед иргэдэд ухаалаг хэлбэрээр төрийн мэдээ мэдээллийг хүргэх, санал хүсэлт

		<p>самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах</p>	<p>өргөдөл гомдлыг хүлээн авах ухаалаг гар утаснуудад зориулагдсан Smart khentii програмыг 2 хувилбараар шинээр хийлгэж цахим орчинд байршуулаад байна.</p>
		<p>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлдэг болох</p>	<p>Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай дамжуулан мэдээлэх, зарлах, санал хүсэлт хүлээн авах зориулалттай тусгай дугаартай холбогдож ажиллах системийг шинээр хийлгэж ашиглахад бэлэн болоод байна.</p> <p>Иргэдийг “Иргэдээ сонсьё- 70563111” дугаарын утсанд хэрхэн холбогдож санал хүсэлт гомдол мэдээллээ өгөх тухай реклам, мөн Хэнтий аймгийн ЗДТГ болоод бусад сумд, агентлагуудын вэб сайтуудын талаар реклам бэлтгэж 2014 оны 2 сарын 25-наас эхлэн Өндөрхаан ТВ-ээр 1 сарын турш нэвтрүүлэн сурталчлав.</p>
		<p>Сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нараас шалгуулахаар шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нээлттэй болгох</p>	<p>“Иргэдээ сонсьё 70563111” төв нь 70563111 тусгай дугаарын утас ажиллуулж, 70563111 факс, 70563111@khentii.mn, хаягаар, биечлэн уулзах зэрэг хэлбэрээр нийт 1193 иргэнээс санал хүсэлт өргөдөл гомдол хүлээн авч 1165 иргэнд хариу өгч шийдвэрлэлт 97%-тай явагдаж байна. Тус төвд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга М.Болд 2014 оны 3-р сарын 05 –нд “ Иргэдтэй уулзах цаг”- телевизийн шууд нэвтрүүлэгт оролцох хэлтэс, агентлагийн дарга нарын хуваарийг баталсны дагуу ТЗУХ-ийн дарга Д.Ганболд, Хууль зүйн хэлтсийн дарга Ж.Ганбаатар, НХХ-ийн дарга Ш.Жавхлан, ХБХ-ийн дарга Д.Эрдэнэбаатар, СТСХ-ийн дарга С.Хэрлэнчимэг, УБХ-ийн дарга Д.Эрдэнэнамжилмаа, Хөдөлмөрийн хэлтсийн дарга А.Жаргалсайхан, НДХ-ийн дарга Д.Өнөрцэцэг, НХҮХ-ийн дарга С.Ганбат, ЭМГ-ын дарга Д.Ганболд, Нэгдсэн эмнэлгийн дарга Н.Орхончимэг, ҮХААГ-ын дарга Ж.Төрмөнх нар оролцож иргэдээс ирүүлсэн санал хүсэлтэд шууд хариулт өгөх, тулгамдаж буй асуудлыг шийдэх, шинээр гарсан хууль тогтоомжийг</p>

			<p>сурталчлан таниулах ажлыг харьяа хэлтэс албадад үүрэг өгөх ажлыг зохион байгуулан ажилласан байна.</p> <p>Аймгийн Засаг даргын А/64 тоот захирамж, Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журам, 7056311 тусгай дугаарын утас, ажиллах цагийн хуваарийг “Иргэдээ сонсьё 3111” төвийн байр болон Khentii.mn сайтад байршуулсан байна.</p> <p>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт мэдээллийг шийдвэрлэсэн талаар 7 хоног тутамд khentii.mn сайтаар, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох “Хэнтий ТВ”-ээр 5 удаа, “Өндөрхаан ТВ” –ээр 4 удаа мэдээлсэн байна.</p> <p>Аймгийн Засаг даргад 160 өргөдөл гомдол ирж, шийдвэрлэж хариу өгсөн 131 буюу 81%, шийдвэрлэх шатандаа 29 буюу 18%-тай явагдаж байна.</p>
15	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p>	<p>Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байдал</p> <p>Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал</p> <p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал,</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ажилтнуудаас авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргахдаа “эрсдэлтэй ажил албан тушаалыг тодорхойлох хуудас”-ны загвар боловсруулан ашигласан бөгөөд 13 ажилтаны эрхэлж буй ажил, албан тушаал эрсдэлтэй албан тушаалд тооцогдсон байна.</p> <p>Уг албан тушаалтнуудад хуулиар зохицуулагдсан хориглолт хязгаарлалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн болно.</p> <p>Мөн ажилтнуудын үйл ажиллагааг хянах зорилгоор аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын даргын тушаалын төслийн зөвшөөрөл олгох хуудсыг өөрчлөн сонирхолын зөрчлийн хуулинд нийцүүлсэн болно.</p> <p>Мөн ажилтнуудад АТГ, Сантмарал судалгааны төвийн хамтран гаргадаг авилгын эрсдэлийн судалгааны дүнг жил бүр танилцуулж хэвшээд байна.</p>

		чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулах/	
16	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх	Зөрчлийг мэдээлэх /байгууллага, албан тушаалтнаас АТГ-т шалгуулахаар харъяаллын дагуу шилжүүлсэн материалд үндэслэн үнэлэх/ АТГ-аас хийсэн шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлээгүй бу-руутай этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэсэн байдал	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэл өгөгдөөгүй болно.
17	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг тооцож ажиллах, хариу хүргүүлэх	Авилгатай тэмцэх газраас 2014оны 7 сарын 18, 8 сарын 22-ний өдрүүдэд ирүүлсэн хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай албан тоотыг хүлээн авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Уг албан бичгийн дагуу хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлэг хянуулалгүй томилогдсон 45 албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлүүлж, зөрчлийг арилгуулан ХАСУМ-ийг хянуулахаар АТГ-т хянуулсан болно. Мөн зарим байгууллагуудад ЭБАТ-ныг албан ёсоор томилуулж, холбогдох нэмэгдлийг олгуулах арга хэмжээ авч, ХАСХОМ гаргаагүй, хугацаа хожимдуулсан ажилтнуудад эрх бүхий этгээдийн шийдвэрээр сахилын шийтгэл ногдуулж дээрх албан бичгийн

			хариуг холбогдох нотлох баримтын хамт хугацаанд нь АТГ-т хүргүүлсэн болно.
18	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх	<p>Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачлагыг дэмжиж ажиллах</p> <p>Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан хөрөнгө зарцуулсан байх</p>	<p>Орон нутаг дахь төрийн тодорхой хэлтэс, албадын хууль дээдлэх, хэрэгжүүлэх, удирдах үйл явцыг сайжруулах замаар ардчилсан засаглалыг бэхжүүлэн, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилго бүхий АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр “Орон Нутгийн Хариуцлагатай Засаглалын төлөөх Идэвхтэй Түншлэл ба Иргэдийн Оролцоо” төслийг Мерси Кор Монгол ОУБ-аас орон нутгийн түншүүдтэйгээ хамтран хэрэгжүүлж байна. Хэнтий аймагт тус төслийг амжилттай хэрэгжүүлэн 2 дуаагийн аяныг зохион байгуулан тодорхой үр дүнд хүрээд байна.</p> <p>“Хууль дүрэм бодит амьдралд-2” аяныг 2014 он гарсаар төслийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2014.02.18-04.18-ны хооронд аяны ажлыг зохион байгуулан явууллаа.</p> <p>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх төр, иргэний нийгмийн байгууллагуудын үр бүтээлтэй хамтын ажиллагааг дэмжих, төслийн хүрээнд хэрэглэгдэх хууль журмуудыг төр захиргааны байгууллага төдийгүй ард иргэдийн түвшинд хэрэгжүүлдэг болоход нь дэмжлэг үзүүлэх, төр иргэний харилцааг сайжруулах, мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх, өмнөх аяны сайн туршлага үйл ажиллагааг бататгах, улам сайжруулахад “Хууль дүрэм бодит амьдралд-2” аяны зорилго чиглэгдсэн.</p> <p>Аймгийн ажлын хэсгийн гишүүд “Хууль дүрэм бодит амьдралд-1” аяны хүрээнд төслийн зорилтот сум бүрээ хариуцан авч аян ажлыг</p>

			<p>нь чиглүүлэн ажиллаж байсан бол “Хууль дүрэм бодит амьдралд-2” аяны хүрээнд APPEAL төслийн хүрээнд хэрэгжиж байгаа 2-р шатны дэд тэтгэлэгийн төслүүдийг нэг нэгээрээ хариуцан авч зөвлөхөөр ажиллав. Үүнд:</p> <p>Ж. Ганбаатар – “Авлигын эсрэг түншлэл ба ТББ, иргэдийн оролцоо” төсөл</p> <p>С.Бат-эрдэнэ – “Иргэний танхим- Иргэдийн индэр” төсөл</p> <p>З.Бат-Эрдэнэ – “Сумын хөгжил- Бидний ирээдүй” төсөл</p> <p>Ш.Одонтуяа – “Төрийн мэдээлэл- Түмний оролцоо” төсөлтэй</p> <p>Ийнхүү аймгийн ажлын хэсгийн гишүүнээс тухайн дэд тэтгэлгийн төслийн багтай харилцан уялдаа холбоотой ажиллаж төслийн багт заавар зөвлөгөө чиглэл өгч хамтран ажилласнээр төслийн үйл ажиллагаа төлөвлөсөн цаг хугацаандаа үр дүнтэй хэрэгжихэд нөлөөлж чадсанаас гадна аяны хүрээнд зохион байгуулсан ажлуудад ИНБ-уудыг хамруулах, дэд төслийн үйл ажиллагаануудыг аяны ажлын агуулгатай хамтатган нийцүүлэх зэрэг байдлаар ажиллан үр дүнтэй зохицуулалт боллоо. <i>/тайланг хавсаргав/</i></p> <p>Мөн аймгийн Засаг даргын 2014 оны 9 сарын 23-ны өдрийн а/523 тоот захирамжаар АТГ-тай хамтран хууль сахиулах байгууллагын ажилтнууд, алба хаагчдад “хууль сахиулах байгууллагуудын шударга байдал, авилгаас ангид байхад нөлөөлөх нь”сэдэвт сургалт зохион байгуулахад 531600төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.Мөн ИНБ-ын 3-р чуулган зохион байгуулахад 1500000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.</p> <p>Аймгийн төрийн байгууллагуудын төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанартай хүргэх, төрийн бодлого боловсруулах үйл</p>
--	--	--	--

			ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, аймгийн хэмжээнд нэгдсэн мэдээллийн орчин үүсгэж, мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээг цахимжуулах, шинэ төрлийн ухаалаг дэд бүтэц байгуулах, шуурхай хяналт удирдлагыг бий болгох зорилгоор ОНХС-ийн 200 сая төгрөгийн санхүүжилтээр “ЦАХИМ ХЭНТИЙ” хөтөлбөрийн хүрээнд “SMART ХЭНТИЙ” программ, төрийн байгууллагуудын мэдээллийн цогц системийг ажиллуулж эхлээд байна.
19	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	<p>Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг зохион байгуулах, зөвлөмж өгөх</p> <p>Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчилд арга хэмжээ шуурхай авах</p> <p>Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчилд хариуцлага тооцож ажиллах</p> <p>Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчилд хариуцлага тооцож ажиллах</p>	<p>2014 оны 1 дүгээр сарын 17-нд АЗДТГ-ын 24 албан хаагчдад ХАСХОМ-ын талаар сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Авлигатай тэмцэх газраас Хэнтий аймгийн ЭБАТ-д 2014 оны 6 дугаар сарын 6-нд ХАСХОМ бүртгэх, хадгалах, хамгаалахтай холбоотой асуудлаар сургалт зохион байгууллаа. 2014 оны 9 дүгээр сарын 20-нд Баянмөнх сумын Төрийн байгууллагын 68 албан хаагчдад Ёс зүйн талаар сургалт, 2014 оны 9 дүгээр сарын 22-нд Батноров сумын Цэцэрлэгийн ажилчдад Ёс зүйн сургалт, 2014 оны 10 дугаар сарын 3-нд АЗДТГ-ын 35 албан хаагчдад ёс зүйн дүрмийн талаархи, 10 сарын 17-нд нууцын тухай хуулиудаар сургалтыг тус тус зохион байгууллаа.</p> <p>Төрийн захиргааны ёс зүйн дүрэм, Захиргааны хэм хэмжээг зөв хэрэглэх, захиргааны шийдвэр гаргах тухай сэдвээр Өмнөдэлгэр сумын албан хаагчдад 2014 оны 10 дугаар сарын 20, Биндэр сумын албан хаагчдад 2014 оны 10 дугаар сарын 21, Дадал сумын албан хаагчдад 2014 оны 10 дугаар сарын 22, Батноров сумын албан хаагчдад 2014 оны 10 дугаар сарын 23-нд нийт 45 албан хаагчдад сургалт зохион байгууллаа.</p>

		<p>АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлтийг хариуцах</p>	<p>АТГ-ын мөрдөн байцаагчийн мэдэгдлийн дагуу Эрдэнэт хун ХХК-д хууль зөрчин газар олгосон Дархан сумын Засаг дарга Ж.Даваад сануулах сахилгын шийтгэл ноогдуулж, хариуг АТГ-т хугацаанд нь хүргүүлсэн болно.</p>
<p>АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ын биелэлтийг хангаж ажиллах</p>			

Биелэлт гаргасан: ХЗХ-ийн дарга

Ж.Ганбаатар

Хянасан: аймгийн ЗДТГ-ын дарга

М.Болд